



2023 оны 3-р сарын 21
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
И-мэйл: communications@amcham.mn
Утас: +976 99091557
Вэб: <https://amcham.mn/publications/1>

Хэвлэлийн мэдээ

АмЧам Монгол “Дараагийн Оюу Толгой хаана байна вэ?” сэдвээр III сарын уулзалтыг зохион байгуулав



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2023 оны 3-р сарын 21-ний өдөр “Дараагийн Оюу Толгой хаана байна вэ?” сэдэвт хэлэлцүүлгийг Шангри-Ла Улаанбаатарт зохион байгуулав.

АмЧам Монголын III сарын хэлэлцүүлэгт гишүүн байгууллага, уул уурхайн салбарын төлөөлөгч нар болох Оюу Толгой компанийн Хөгжил хариуцсан ерөнхий захирал Жак Ван Тондер, Бадах Энержи компанийн гүйцэтгэх захирал Марк Мелиард, Монгол Нүүрс Холбооны Гүйцэтгэх захирал Ж. Золжаргал, Эдийн засагч Б. Мөнхсоёл нар панелистаар оролцож, АмЧам Монголын ТУЗ-ын Тэргүүн Гари Биондо модератороор ажиллав. Өнөөдрийн хэлэлцүүлгийн гол зорилго нь дараагийн Оюутолгой шиг мега төсөл хаана байгаа вэ, үүнийг хэрхэн олж тогтоох вэ, Засгийн газар болон олон нийт хэрхэн дэмжиж, үр шимийг нь нийтээрээ хүртэх боломжтой талаар хэлэлцэж, олон нийтийн анхааралд оруулах юм. Мэдээж уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах гол салбар мөн. Бид баялгаа олборлож, эдийн засгаа хөгжүүлж, урагшлах ёстой. Гэхдээ дараагийн Оюутолгой зөвхөн уул уурхайн салбараас гадна, хөдөө аж ахуй, цахим эдийн засаг, инноваци технологийн чиглэлд маш их боломжууд монголчууд бидний өмнө байна.

Дараагийн Оюутолгойн төсөл хаана байгаа талаар панелистуудын өөр өөрийн байр суурийг илэрхийлэв. Монгол Нүүрс Холбооны Гүйцэтгэх Захирал Ж. Золжаргал “Хөрөнгө оруулагчийг уриалгаар татахгүй. Ашиг хийх бодит нөхцлөөр татна. Тэр нь татварын хөнгөлөлт. Дэлхийн хамгийн том зах зээл Хятадын хаяа дэрлэн оршдог Монголд хөрөнгө оруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортолбол татвараас шууд чөлөөлж, хөнгөлөх хэрэгтэй байна. Ингэж бүх салбарт том жижиг хөрөнгө оруулагчдыг татаж, Монгол орныг нээх нь монголчуудын эрх ашигт нийцнэ. Дараагийн Оюутолгой бол Монгол Улс бүхлээрээ юм. Тиймээс бүх салбарт хөрөнгө оруулалтыг татах татварын таатай орчныг бүрдүүлэх хэрэгтэй гэж” онцлов.



Харин Эдийн засагч Б. Мөнхсоёл хэлэхдээ “Засаглалыг сайжруулж, авлигаас ангид байж чадвал Монгол улсад зөвхөн дараагийн том уул уурхайгаас гадна эдийн засаг төрөлжих, хөдөө аж ахуйн салбараас ихээхэн орлого олох боломж бий. Гагцхүү хууль эрх зүйн орчинг сайжруулах, хэрэгжүүлэх, шүүхийн бие даасан байдлыг хангах, улс төрийн аливаа сөрөг, тогтворгүй шийдлийг гаргахгүй байх нь тулсан асуудал болжээ” гэв.

Бадрах Энержи ХХК-ийн Гүйцэтгэх захирал Марк Мелиард хэлэхдээ “Манай компани Монгол улсад гадаадын томоохон хөрөнгө оруулагчийг төлөөлж, ураны ордоос олборлолт хийх ажлыг гүйцэтгэгчийн хувьд стратегийн салбарт Франц, Монгол хоёр улсын хоёр талын ашиг сонирхолд нийцсэн чухал төслийг урагшлуулахад бэлэн байгаа. Бадрах энерги нь "Дараагийн Оюутолгой" байж болох юм” гэж онцлон тэмдэглэв.



АмЧам Монголын Тэргүүн Гари Биондо хаалтын хэлсэн үгэндээ “Дараагийн Оюу Толгой аль ч салбар, аль ч төсөл байсан, бид хууль, эрх зүй, гадаадын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ажлуудыг заавал хийх хэрэгтэй гэдэгтэй бүгд санал нийлэх байх” хэмээн онцлов.

Хэлэлцүүлгийн төгсгөлд АмЧам Монголын шинэ гишүүн Сайн Скор ХХК, Снөү Хилл Консалтинг ХХКомпанийн төлөөлөгч нарт баяр хүргэж, гишүүнчлэлийн өргөмжлөл гардуулав.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.